БАТЛАВ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Б.МЭНДБАЯР

7 ДУГААР БАГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ 260 М УРТ ЧУЛУУН ЗАМ, ЯВГАН ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2026.01.08 Дугаар ӨМДЗСЗДТГ/20260203078 Даланзадгад

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	Даланзадгад сум/хот/-ыг 2024-2028 онд хөгжүүлэх засаг даргын үйл ажиллагааны "Өсөлттэй Даланзадгад хот" хөтөлбөр, Даланзадгад сумын Хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөө
2	Барилга байгууламжийн байршил	• Оюутын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт
3	Авто замын ангилал	Автозам, явган зам, гэрэлтүүлэг, гэрлэн дохио, тэмдэг, тэмдэглэгээ
4	Замын эхлэл,төгсгөл	Төлөвлөлтийн шаардлагаас хамаарч захиалагчтай зөвшилцөх
5	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
6	Замын хучилтын хийц	Тооцоогоор
7	Авто зогсоолын хучлага	Тооцоогоор
8	Төлөвлөлтийн норм	Авто замын ажлын зургийг Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ тооцох аргачлал 2018 "Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" БНбД 30.01.04, "Авто зам төсөллөх" ЗЗБД22-004-2016, "Авто замын гүүр ба хоолой төсөллөх" БНбД 32-02-12, Монгол улсын стандарт Авто замын салбарт мөрдөх стандартын замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрлэн дохио, хашилт чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм MNS 4596:2014, MNS 4597:2014, MNS 4759:2014, MNS 4980:2014, Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм ЗЗБНбД 81-013-2019 "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм", Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам, Нийтийн тээвэр замналын зогсоол. Ангилал. Техникийн шаардлага MNS 5879:2012 болон бусад холбогдох норм дүрэм стандартуудыг үндэслэх, "Геодези зураг зүйн тухай" хуулийн 6.1.3 дугаар заалт, "Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" БНбД 11-07-04-ын II хэсэг инженер геодезийн ажил, "Геодезийн ажил "БНбД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу зураг төслийг боловсруулах,

9	Зураг төслийн баримт зохиох үе шат, хугацаа	1 үе шаттай. Гэрээнд заасан хугацаанд.
10	Зураг төслийн иж бүрдэл	1. Геодезийн ажлын тайлан 2. Инженер-геологийн судалгааны ажлын тайлан 3. Холбогдох техникийн нөхцөлүүд 4. Авто зам, замын байгууламжийн инженерийн нарийвчилсан зураг төсөл 5. Зургийн тайлбар бичиг 6. Техникийн шаардлага 7. Ажлын нэр төрөл, тоо хэмжээ 8. Барилгын ажлын төсөв 9. Магадлалын дүгнэлтүүд
11	Зургийн байгууллага	"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу сонгон шалгаруулна.
12	Захиалагч байгууллага	Даланзадгад сумын Засаг даргын Тамгын газар
13	Онцгой нөхцөл	- Хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд тулгуурлан хийх, геодези, байр зүйн зураглалын ажлын иж бүрэн тайланг батлуулан хүлээлгэн өгөх, зам барилгын ажлын үед геометр хэмжээг хангах, хэмжилтийн төсөл-даалгавар боловсруулах. - Инженер геологийн судалгаа хийж, хэсэг бүрд хөрсний геотехникийн үзүүлэлтүүдийг нарийвчлан тогтоон замын байгууламжийн бүтээцийг тооцоогоор оновчтой сонгох. - Шороон ордын /карьер/ судалгааг дүүргэгч бүрээр тодорхойлж, тооцоолох. - Автозамын зорчих хэсгийн төлөвлөлтийг огтлолцож буй болон холбогдож буй бүх талын замын төлөвлөлттэй уялдуулах, захиалагчийн саналыг тусгах, - Автозам, уулзварын хөдөлгөөн зохион байгуулалтыг оновчтой төлөвлөх. - Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тэмдэг, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд тусгах ба зураг төслийг боловсруулахдаа холбогдох байгууллагуудтай зөвшилцсөн байх. - Зургийн тайлбар бичигт төсөллөж буй авто зам, уулзвар, авто зогсоол болон бусад байгууламжийн товч тодорхойлолт, ашиглагдаж буй авто зам, гүүрний техник ашиглалтын нөхцөл, автозам баригдах газрын байгаль цаг уурын статистик мэдээ, трассын дагууд инженер геологийн эрэл хайгуулын судалгааны дүгнэлтийн тайлан /зам барилгын материалын карьеруудын байршлын хамт/, геодезийн хэмжилтийн иж бүрэн тайлан, зам барилгын ажлын тоо хэмжээ, зам барилгын ажилд тавигдах шаардлага орсон байна.

		- Зураг төслийг дараах масштабтайгаар боловсруулна. Үүнд: Дэвсгэр зураг 1:500 Дагуу огтлол хэвтээ 1:2000 Босоо огтлол 1:200 Хөндлөн огтлол 1:200 Уулзвар, огтлолцол 1:500 Бүтээц 1:20 Авто зам, замын байгууламжийн ажлын зураг, тайлбар бичиг, инженер геологийн дүгнэлт, геодезийн ажлын тайлан, техникийн шаардлага, инженерийн шугам сүлжээний ажлын зураг бусад холбогдох бичиг баримтыг эх хувь 1ш, хуулбар хувь 3ш (хуулбар хувийг өнгөтөөр хувилах), тоон хэлбэрээр /DWG болон PDF/, батлагдсан зураг төсвийн рендер зургийг гарган хамт USB зөөврийн санах ой-нд хавсарган захиалагчид хүлээлгэж өгнө.

<u>БОЛОВСРУУЛСАН:</u>
ДЭД БҮТЭЦ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН: Э.ЖАМЦДОРЖ

7 дугаар багийн нутаг дэвсгэрт зураг төсөв боловсруулах замын байршил.